ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/016 /НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Дэвжих Капитал аудит ХХК-ийн захирал : Л.Отгон<br>Утас: 99059489 Цахим хаяг: devjikhcapital.audit@gmail.com<br>Аудитор: Ц.Базарсад<br>Утас: 99065336 Цахим хаяг: bazka0330@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.24 № 77

танай ____________ -ны № ______________ -т

ЕСӨНБУЛАГ СУМЫН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
И.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 29,301.4 мянган төгрөгөөр өссөн, орон нутгийн төсвийн санхүүжилт 17,237.3 мянган төгрөгөөр буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд 3,410.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авч, хөрөнгийн дахин үнэлгээгээр 14,180.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 15,253.5 мянган төгрөгөөр буурсан, 1,885.5 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 56 дугаар тогтоолын дагуу акталсан байна.

**Бусад асуудал**

Тайлант онд 1 хөтөлбөр, 6 зорилт, 68 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 68 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг 95.0 хувиар үнэлэн

8225050000215

хүргүүлсэн бөгөөд аймгийн Боловсролын газраас 88.0 хувиар "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **156,816,654.56** | **107,555,959.98** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 56,688,027.71 | 2,668,392.59 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 56,688,027.71 | 2,668,392.59 |
| **3121** | **Төгрөг** | 56,688,027.71 | 2,668,392.59 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 56,688,027.71 | 2,668,392.59 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 100,128,626.85 | 104,887,567.39 |
| **351** | **Түүхий эд материал** | 52,153,441.72 | 57,074,651.08 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 52,153,441.72 | 57,074,651.08 |
| **354** | **Хангамжийн материал** | 47,975,185.13 | 47,812,916.31 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,769,500.00 | 1,769,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,909,040.00 | 33,315,849.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,252,000.00 | 3,252,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,832,576.00 | 6,400,480.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,212,069.13 | 3,075,087.31 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **551,869,038.10** | **533,797,280.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 551,869,038.10 | 533,797,280.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | 461,335,538.06 | 443,588,780.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 499,246,623.65 | 499,371,623.65 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (92,812,458.52) | (108,599,650.84) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 46,092,085.00 | 44,088,185.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (15,834,534.16) | (17,637,420.16) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,433,090.00 | 28,723,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,549,823.08) | (13,555,289.89) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 14,100,000.00 | 14,140,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,339,444.83) | (2,941,666.87) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 90,533,500.04 | 90,208,500.08 |
| 39301 | Програм хангамж | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (662,499.96) | (987,499.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 89,996,000.00 | 89,996,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **708,685,692.66** | **641,353,240.95** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,012,579.00** | **16,326,295.09** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,012,579.00 | 16,326,295.09 |
| **413** | **Өглөг** | 4,012,579.00 | 16,326,295.09 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 775,089.14 |
| **4136** | **Бусад өглөг** | 4,012,579.00 | 15,551,205.95 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,012,579.00 | 15,551,205.95 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **704,673,113.66** | **625,026,945.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 704,673,113.66 | 625,026,945.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 317,817,542.00 | 317,817,542.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 317,817,542.00 | 317,817,542.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 217,256,508.16 | 137,610,340.36 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 219,063,857.14 | 217,256,508.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (1,807,348.98) | (79,646,167.80) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 169,599,063.50 | 169,599,063.50 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **708,685,692.66** | **641,353,240.95** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **797,488,450.00** | **816,447,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,140,950.00** | **23,036,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,140,950.00 | 23,036,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,604,950.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,604,950.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 12,070,000.00 | 17,590,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,466,000.00 | 5,446,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **781,347,500.00** | **793,411,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 696,602,300.00 | 725,903,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 696,602,300.00 | 725,903,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 84,745,200.00 | 67,507,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,745,200.00 | 67,507,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **799,295,798.98** | **896,093,767.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **799,295,798.98** | **896,093,767.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 799,295,769.77 | 896,063,067.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 550,793,623.64 | 635,098,959.63 |
| 210101 | Үндсэн цалин | 479,542,841.55 | 411,002,375.69 |
| 210102 | Нэмэгдэл | 55,669,782.09 | 178,961,519.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 23,515,723.95 |
| 210104 | Урамшуулал | 15,581,000.00 | 21,619,340.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 69,267,991.27 | 79,743,289.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,444,580.38 | 54,708,384.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,583,200.00 | 6,436,280.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,791,600.00 | 3,179,200.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,687,146.24 | 3,083,884.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,761,464.65 | 12,335,539.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 75,042,258.29 | 74,046,526.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,480,402.29 | 8,134,570.95 |
| 210302 | Түлш, халаалт | 54,679,680.00 | 54,679,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,882,176.00 | 11,232,276.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,353,177.84 | 2,514,313.46 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,353,177.84 | 2,514,313.46 |
| **2105** | **Нормативт зардал** | 42,182,061.00 | 48,144,186.00 |
| 210502 | Хоол, хүнс | 42,182,061.00 | 48,144,186.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,553,491.50 | 4,969,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,553,491.50 | 4,969,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,570,000.00 | 2,168,135.49 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,570,000.00 | 2,168,135.49 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,533,166.23 | 49,378,357.13 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,346,900.00 | 9,645,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,011,500.00 | 4,071,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,174,766.23 | 35,661,757.13 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29.21 | 30,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 29.21 | 30,700.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29.21 | 30,700.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(1,807,348.98)** | **(79,646,167.80)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,807,348.98)** | **(79,646,167.80)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 783,952,450.00 | 793,411,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,604,950.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,604,950.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,604,950.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,604,950.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 781,347,500.00 | 793,411,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 696,602,300.00 | 725,903,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 696,602,300.00 | 725,903,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 84,745,200.00 | 67,507,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,745,200.00 | 67,507,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 767,632,824.91 | 847,431,235.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 767,632,824.91 | 847,431,235.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 767,632,795.70 | 847,400,535.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 550,793,623.64 | 635,088,959.63 |
| 210101 | Үндсэн цалин | 357,582,329.98 | 411,002,375.69 |
| 210102 | Нэмэгдэл | 162,782,111.66 | 178,951,519.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 23,515,723.95 |
| 210104 | Урамшуулал | 30,429,182.00 | 21,619,340.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 69,267,991.27 | 78,978,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,444,580.38 | 53,573,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,583,200.00 | 6,351,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,791,600.00 | 3,175,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,687,146.24 | 3,175,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,761,464.65 | 12,702,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 71,029,679.29 | 62,507,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,480,402.29 | 8,516,919.68 |
| 210302 | Түлш, халаалт | 54,679,680.00 | 44,453,401.32 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,869,597.00 | 9,537,579.00 |
| 2105 | Нормативт зардал | 45,184,410.00 | 45,712,090.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,184,410.00 | 45,712,090.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,215,491.50 | 4,969,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,215,491.50 | 4,969,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,570,000.00 | 2,168,135.49 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,570,000.00 | 2,168,135.49 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,571,600.00 | 17,975,950.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,148,800.00 | 12,759,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,422,800.00 | 5,216,450.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29.21 | 30,700.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 29.21 | 30,700.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29.21 | 30,700.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 16,319,625.09 | (54,019,635.12) |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 2,341,600.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,341,600.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,341,600.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,341,600.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (2,341,600.00) | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 13,978,025.09 | (54,019,635.12) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 42,710,002.62 | 56,688,027.71 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 56,688,027.71 | 2,668,392.59 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 317,817,542.00 | 169,599,063.50 | 219,063,857.14 | 706,480,462.64 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **317,817,542.00** | **169,599,063.50** | **219,063,857.14** | 706,480,462.64 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (1,807,348.98) | (1,807,348.98) |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **317,817,542.00** | **169,599,063.50** | **217,256,508.16** | 704,673,113.66 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **317,817,542.00** | **169,599,063.50** | **217,256,508.16** | 704,673,113.66 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **317,817,542.00** | **169,599,063.50** | **217,256,508.16** | 704,673,113.66 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (79,646,167.80) | (79,646,167.80) |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **317,817,542.00** | **169,599,063.50** | **137,610,340.36** | 625,026,945.86 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН (ТӨГРӨГӨӨР)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт хэмнэлт | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **852,372,100.00** | **847,400,535.12** | **4,971,564.88** | **99.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **852,372,100.00** | **847,400,535.12** | **4,971,564.88** | **99.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **852,372,100.00** | **847,400,535.12** | **4,971,564.88** | **99.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 635,128,000.00 | 635,088,959.63 | 39,040.37 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 434,500,000.00 | 411,002,375.69 | 23,497,624.31 | 94.6 |
| 210102 | Нэмэгдэл | 186,969,400.00 | 178,951,519.99 | 8,017,880.01 | 95.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 23,515,723.95 | (23,515,723.95) | - |
| 210104 | Урамшуулал | 13,658,600.00 | 21,619,340.00 | (7,960,740.00) | 158.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,978,200.00 | 78,978,200.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,573,100.00 | 53,573,100.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,351,300.00 | 6,351,300.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,175,600.00 | 3,175,600.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,175,600.00 | 3,175,600.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,702,600.00 | 12,702,600.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 62,507,900.00 | 62,507,900.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,950,400.00 | 8,516,919.68 | (566,519.68) | 107.1 |
| 210302 | Түлш, халаалт | 46,157,500.00 | 44,453,401.32 | 1,704,098.68 | 96.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,400,000.00 | 9,537,579.00 | (1,137,579.00) | 113.5 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | | | |
| **2105** | **Нормативт зардал** | 49,695,400.00 | 45,712,090.00 | 3,983,310.00 | 92.0 |
| 210502 | Хоол, хүнс | 49,695,400.00 | 45,712,090.00 | 3,983,310.00 | 92.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000.00 | 4,969,300.00 | 30,700.00 | 99.4 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,969,300.00 | 30,700.00 | 99.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,823,500.00 | 2,168,135.49 | 655,364.51 | 76.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,823,500.00 | 2,168,135.49 | 655,364.51 | 76.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,239,100.00 | 17,975,950.00 | 263,150.00 | 98.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,022,600.00 | 12,759,500.00 | 263,100.00 | 98.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,216,500.00 | 5,216,450.00 | 50.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **852,372,100.00** | **847,400,535.12** | **4,971,564.88** | **99.4** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 729,886,900.00 | 725,903,700.00 | 3,983,200.00 | 99.5 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 729,886,900.00 | 725,903,700.00 | 3,983,200.00 | 99.5 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 67,507,900.00 | 67,477,200.00 | 30,700.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 67,507,900.00 | 67,477,200.00 | 30,700.00 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 54,977,300.00 | 54,019,635.12 | 957,664.88 | 98.3 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 54,977,300.00 | 54,019,635.12 | 957,664.88 | 98.3 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 56,688,027.71 | (56,688,027.71) | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 2,699,092.59 | (2,699,092.59) | - |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулагдаагүй 7,342.1 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар 7,342.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 4 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### Нэг. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 23,765.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан төсвийн хүрээнд зарцуулах.

**Хоёр. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт тусгагдаагүй архив, бичиг хэргийн албан тушаалын ажил хавсруулж, 2,392.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хүрээнд албан хаагчдад ажил хавсран гүйцэтгэх цалингийн зардлыг төсөвт тусгуулан, батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах.

**Гурав. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бараа үйлчилгээний бусад зардлаас урсгал засварын зардалд 4,827.3 мянган төгрөг зарцуулсан боловч анхан шатны баримтжуулалт шаардлага хангахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтжуулалтыг стандартын дагуу хөтөлж, тайлагнах

**Дөрөв. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Хүүхдийн хоолны зардлыг 122.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хоолны материалын зарцуулалтыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* *(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | То о | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4 дүгээр цэцэрлэг | Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 23,765.0 мянган төгрөгийг олгосон байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| | Батлагдсан төсөвт тусгагдаагүй хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын ажилтны албан тушаалын ажил хавсруулж, 2,392.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна. | 1 | 2,392.0 | - | - | - | - | 1 | 2,392.0 | - | - |
| | Бараа үйлчилгээний бусад зардлаас урсгал засварын зардалд 4,827.3 мянган төгрөг зарцуулсан боловч анхан шатны баримтжуулалт шаардлага хангахгүй байна. | 1 | 4,827,3 | - | - | - | - | 1 | 4,827,3 | - | - |
| | Хүүхдийн хоолны зардлыг 122.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. | 1 | 122.8 | - | - | - | - | 1 | 122.8 | - | - |
| **Дүн** | | **4** | **7,342.1** | - | - | - | - | **4** | **7,342.1** | - | - |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | | **1** | | | **1** | | | |